

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ УДИРДЛАГА

ГАМШГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООХ ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Г.БАТ-ЭРДЭНЭ

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа


Хураангуй: Манай орны онцлогт нийцсэн гамшгийн шалгуур үзүүлэлт нарийвчлан боловсруулагдаагүй байгаа нь гамшгаас хамгаалах салбарт удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгох, авч хэрэгжүүлэх арга хэмжээний цар хүрээг тогтоох, олон улсын хэмцээнд харилцан ойлголцож, хамтран ажиллах, гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа, шинжилгээ явуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааны үр дүнг бодитой тооцох гэх мэт олон чиглэлд тодорхойгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Гамшгийг эрдэмтэн, судлаачид өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж өөрсдийн үзэл бодлын үүднээс өөр хоорондоо илт зөрүүтэй биш олон янзын тодорхойлолт гаргасан байдаг.

Гамшгийн аюул бол ирээдүйд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлын утгвар юм¹.

Дээрх бүгдээс үзэхэд “Гамшиг” гэсэн үндсэн ойлголтыг бүрэн тодорхойлж чадаагүйгээс түүнийг аюул, эмзэг байдал, гамшгийн цар хүрээ, хохирол гэсэн нэмэлт ойлголтуудаар тодотгох шаардлагыг бий болгож байна.

Монгол улсад ихэвчлэн тохиолддог гамшиг, аюулт үзэгдлийг ангилал:



Манай улсад гамшгийн шалгуур үзүүлэлтийг дан ганц аюулын шинж чанарт нь тулгуурлан тогтоосон баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолоор баталсан “Сэрэмжлүүлэх болон урьдчилан

¹ О Үржин, 2004, “Гамшгийн менежмент” 3 боть, х. 5

сэргийлэх мэдээнд орох ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн жагсаалт" бөгөөд зөвхөн байгалийн гаралтай аюулт үзэгдэл ямар эрч хүч, цар хүрээтэй тохиолдвол гамшиг гэж үзэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

Түлхүүр үг: Гамшгийн ангилал, ангилал. шалгуур үзүүлэлт, онол, арга зүй.

Оршил

Ш.Паламдорж. П.Цэдэв (2010) нарын эрдэмтэд “Тамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй” бүтээлдээ гамшгийг хүний амь нас хохирсон, олон хүний эрүүл мэндэд аюул нүүрлэсэн, эд хөрөнгийн хохирол тодорхой хэмжээнд хүрсэн, баг (хороо), сум (дүүрэг). аймаг, нийслэл, бүс нутгийн хүч хэрэгсэл. нөөц хөрөнгөөр сэргээн босгох чадвар зэрэг үзүүлэлтийг авч үзэж гамшгийн шалгуурыг дараах хүснэгтэд үзүүлснээр тогтоож гамшгийг зэрэглэсэн байна (хүснэгт 1).

Хүснэгт 1.

Манай орны хувьд гашигт үзэгдлийн аюулын хэмжээр үзүүлэлт. түүнд оролцох удирдлага. харьцуулан авч үзсэн хүснэгт'

	Ангилал	Амь насаа алдсан	Эрүүл мэндэд хохирол учруулсан	Эд хөрөнгө, материалын хохирол үзсэн*	Удирдлага	Оролцох хүч хэрэгсэл
1	Объектын (ААНБ) хэмжээний	10 хүн	20 хүн	Үндсэн хөрөнгийн үнийн дүнгийн 40 хувь	Объект, сум (хороо)-ын удирдлага	Объект, сумын мэргэжлийн анги
2	Баг, хорооны хэмжээний	10 хүн	30 хүн	100 сая төгрөгийн хохирол	Сум (хороо)- ын удирдлага	Сумын мэргэжлийн анги
3	Сумын хэмжээний	10 хүн	50 хүн	200 сая төгрөгийн хохирол	Аймгийн удирдлага, ОБ хэлтэс	Аймгийн ОБХ-ын анги, отряд, салбар
4	Аймгийн хэмжээний	10 хүн	75 хүн	300 сая төгрөгийн хохирол	Бүсийн удирдлага, ОБЕГ	Бүсийн, ОБЕГ, Шуурхай анги, отряд, салбар
5	Бүс нутгийн хэмжээний	10 хүн	100 хүн	500 сая төгрөгний хохирол	Улсын Онцгой комисс, ОБЕГ	ОБЕГ, Шуурхай анги, отряд, салбар, ЗХ-ий анги, бүлэг
6	Улсын хэмжээний	10-аас дээш хүн	100-аас дээш хүн	500 саяас дээш төгрөгний хохирол	Засгийн газар, УОК, ОБЕГ	ОБЕГ, ЗХ-ий анги. салбар
7	Хил дамнасан 2-3 улсын хэмжээнд	Амь насаа алдсан, нэрвэгдсэн хүний тоо хэдэн арав, зуугаас дээш болж олон зуун сая төгрөгийн хохирол учирсан байх нөхцөл бүрдэнэ			Монгол Улсын Ерөнхийлөгч , УИХ, ЗГ, УОК, ОБЕГ	ОБЕГ, ЗХ-ий анги, салбар, ОУ-ын хамтарсан хүч

Тайлбар: *-энд дурдсан тоон болон хувь заасан үзүүлэлт бол нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөх хувьсах хэмжигдэхүүн

Гамшгийн эдгээр шалгуурыг дан ганц аюулын шинж чанарт нь үндэслэж аль эсвэл нийгэмд учруулах сөрөг үр дагаврыг нь үндэслэн тогтоосон баримт бичиг болон судалгааны үр дүн нь өөр өөрийн давуу талтай байж болох ч гамшгаас салбарт ашиглагдахуйц тодруулбал “гамшиг” гэдэг үндсэн ойлголтыг бүрэн илэрхийлэхүйц гамшгийн шалгуур үзүүлэлт болж чадахгүй, учир нь гамшиг бол аюулын шинж чанар. түүний нийгэмд үзүүлэх хор уршгаар илэрхийлэгдэнэ.

Гамшгийн шалгуур үзүүлэлтийг бүрдүүлэгч хүчин зүйлийг үндэс болгон гамшгийн шалгуур үзүүлэлтийг үндсэн болон туслах шалгуурыг ашиглан тодорхойлох боломжтой.

Гамшгийн үндсэн шалгуур нь тухайн аюулын шинж чанарт үндэслэх бол туслах шалгуур нь түүний учруулах хор уршигт тулгуурлана.

Гамшгийн туслах шалгуурт гамшгийг тодорхойлох үндсэн шинжийн нэг болох аюулын учруулах хор уршиг болон өртсөн нийгмийн чадавхаас хэтэрсэн байх гэсэн хоёр үндсэн нөхцлийг авч үзсэн.


Учруулсан хор уршгийн хүрээнд хүн, мал, амьтан, хүрээлэн буй орчин, нэрвэгдсэн газар нутаг гэсэн үзүүлэлтээр илэрхийлсэн. Энд нэг зүйлийг тэмдэглэн хэлэхэд хотжилт сулхан хөгжсөн, хүн ам сийрэг суурьшдаг, нүүдлийн хэвшил давамгайлсан манай орны хувьд гамшгийн шалгуур үзүүлэлтэд нэн ялангуяа байгалийн гамшгийн хувьд малын хорогдлыг тооцох зайлшгүй шаардлагатай юм.

Монгол орон эрс тэс уур амьсгалтай эрсдэл ихтэй, ихээхэн эмзэг бүс нутагт оршдогтой холбоотойгоор байгалийн гаралтай олон төрлийн аюулт үзэгдэл тохиолдохын зэрэгцээ уул уурхайн эрчимтэй хөгжил, хотжилт, техник, технологийн хөгжлийн нөлөөгөөр хүний үйл ажиллагаанаас үүдсэн осол мөн нилээдгүй олон төрөл тохиолдож болох нөхцөл бий болсон.

Манай оронд тохиолдож болзошгүй гамшгийн төрөл тус бүрээр гамшгийн шалгуур үзүүлэлтийг үндсэн ба туслах үзүүлэлтээр гаргах нь зүйтэй.

Зураг 1.

Монгол орны нөхцөлд гамшгийн шалгуур үзүүлэлт тогтооход авч үзэх хүчин зүйлс.



Гамшгийг ийнхүү анхдагч болон хоёрдогч шалгуураар авч үзэх нь онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг тогтоох, гамшгийн дараах хор уршгийг арилгах, хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгох асуудлыг оновчтой шийдэх үндэслэл болж өгөх ач холбогдолтой юм.

Үндсэн шалгуурыг хангаад туслах шалгуураас аль нэг нь биелж байх нөхцөлийг гамшиг гэж үзэж энэхүү шалгуураар сүүлийн 2 жилд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээнд боловсруулалт хийхэд манай орны хувьд жилд ойролцоогоор нийт тохиолдлын 3-4 хувь нь гамшгийн түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 2.

Тохиолдсон аюулт үзэгдэл, осолд гамшгийн тоо, эзлэх хувь

	Тохиолдсон аюулт үзэгдэл, осол		2017 он			2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар		
			Нийт ТОО	гамшиг	Гамшг ийн эзлэх хувь	Нийт ТОО	гамшиг	Гамшг ийн эзлэх хувь
1	Гал түймэр	ой, хээрийн түймэр	225	71	31.5%	71	14	19.7%
2		Объектын түймэр	3536	42	11 %	3040	38	12%
3	Ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл	Зуд	1			1		
4		Аадар бороо, үер	17	3	17%	72	23	31.9%
5		аянга	13			2		

6		Хүчтэй салхи, шуурга	23	5	21.7%	15	4	26.6%
7	Геологийн гаралтай аюулт үзэгдэл	Газар хөдлөлт	42			29		
8	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Хүний халдварт өвчин	1			-		
9		Малын халдварт өвчин	204	25	12.2%	191	22	11.5%
10	Хүний үйл ажиллагаатай холбоотой осол	Сум галт хэрэгслийн осол	6			8		
11		Химийн бодис	13			15		
12		Цацрагийн осол	1			-		
13		Бичил уурхай, нурангины осол	5			7	3	42.0%
14		уулын осол	2	2	100%			
15		Усны осол	89	9	10%	91	5	5.0%
Бүгд			4194	157	3.7%	3546	109	3.0 %


Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газар. Гамшиг судлалын хүрээлэнгээс гаргасан 2017, 2018 оны 10 дугаар сарын нөхцөл байдлын мэдээнд үндэслэн боловсруулалт хийв.

Жилд тохиолдож байгаа 4000 гаруй аюулт үзэгдэл, ослын ойролцоогоор 4 орчим хувь нь гамшгийн түвшинд хүрдэг гэвэл үлдсэнийг нь зөвхөн үндсэн шалгуурыг хангаж байгаа тохиолдолд аюулт үзэгдэл, осол тохиолдсон гэж, үндсэн шалгуурыг хангаад дээр нь аврах, хор уршгийг арилгах ажиллагаанд онцгой байдлын албанаас хүч хэрэгсэл гарч ажилласан бол онцгой байдал үүссэн гэж ангилж үзвэл нийт тохиолдлын 40 гаруй хувьд нь онцгой байдал үүссэн, үлдсэн 50 гаруй хувь нь тохиолдол ангилалд орж байна.

Зураг

2.

Шалгуур үзүүлэлтэд үндэслэн аюулт үзэгдэл, ослын тохиолдлыг ангилсан байдал



Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэнгээс гаргасан 2017, 2018 оны 10 дугаар сарын нөхцөл байдлын мэдээнд }-ндэслэн боловсруулалт хийв

Өөрөөр хэлбэл бид гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, ангилал тодорхойгүй байдлаас шалтгаалан тохиолдож буй бүх аюулт үзэгдэл, ослыг гамшигт бүртгэж байгаа нь бидний дутагдал болоод байна. Тухайлбал:

Дэлхий дахинд тохиолдсон гамшгийн талаарх мэдээ мэдээллийг бүртгэдэг нэр хүнд бүхий эх сурвалж болох Бельги дэх Люваны их сургуулийн Гамшгийн дэгдэлтийг судлах төвийн мэдээгээр 2017 онд дэлхий дахинд 593. Ази тивд 224 гамшиг тохиолдсон бол манай улсад 4194 гамшиг буюу аюулт үзэгдэл, осол тохиолдсон гэж бүртгэгдсэн байна. Сүүлийн арван жилийн статистикаас үзэхэд дэлхийд жилд дундажаар 629 гамшиг, Ази тивд 255 байхад Монгол Улсад 3356 буюу объектын түймэр ороогүй 456 удаагийн аюулт үзэгдэл осол тохиолдсон байна.

Хүснэгт 3.

Гамшгийн тоо. дэлхий дахинд. Ази тивд. Монгол Улсад 2008-2017

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Дундаж
Дэлхийд (Гамшгийн дэгдэлтийг судлах төв)	628	598	646	590	552	531	518	581	604	593	629
Ази тивд (Гамшгийн дэгдэлтийг судлах төв)	240	233	253	235	211	229	224	206	214	235	255
Монголд (объектын түймэр орсон)	2751	2457	2976	3548	4047	4467	4928	5,426	4381	4194	3356
Монголд (объектын түймэр ороогүй)	414	292	435	485	546	648	706	719	665	658	456

Эх сурвалж: Бельги дэх Люваны их сургуулийн Гамшгийн дэгдэлтийг судлах төв, Монгол Улс Онцгой байдлын ерөнхий газраас гаргасан мэдээнд боловсруулалт хийв

Өөрөөр хэлбэл гамшгийн ангилал, зэрэглэл, шалгуур үзүүлэлт боловсронгуй бус байгаагаас шалтгаалан аюулт үзэгдэл, ослын дуудлага, ажилласан хүч хэрэгсэл, учруулсан хохирлын тоон утгаар гамшгийг бүртгэж байна.

Гамшгийн зэрэглэл нь гамшгийн шалгуур үзүүлэлтүүдээр илэрхийлэгдэх гамшгийг хооронд нь харьцуулах боломж олгох хэмжигдэхүүн юм¹.

АНУ-ын Пеннсилваны их сургуулийн эрдэмтэн Henry W.Fischer ¹ гамшгийн зэрэглэл тогтоох асуудлыг дэвшүүлэн тавьсан өгүүлэлдээ ‘Тамшгийн

¹MNS 6010:2009 Гамшгийн нэр томъёо, ерөнхий анги стандарт

зэрэглэл нь судлаачид болон мэргэжилтнүүдийн аль алинд нь их чухал хэрэгсэл юм. Зэрэглэл нь судлаачдад гамшгийн цар хүрээг ялгаж авч үзэх боломж олгоно. Мэргэжилтнүүд, шийдвэр гаргагчдад бэлэн байдал хангах, хор уршгийг арилгах ажиллагааг оновчтой хэрэгжүүлэхэд нь туслана” хэмээн ач холбогдлыг нь тодорхойлсон.

Түүний энэхүү ангилал нь аюулт үзэгдэл, ослын учруулах хор уршиг болон түүнийг даван туулах чадвар хоорондын харьцаанд үндэслэж хийгдсэнээр онцлог юм. Учир нь тэрээр болзошгүй гамшигт болон гамшгийн дараа нийгэм, олон нийт хэрхэн хариу арга хэмжээ авч байгааг судлах гамшгийн нийгмийн судалгааны чиглэлээр ажилладаг судлаачийн хувьд гамшгийг нийгэмд хэрхэн нөлөөлөх, энэхүү нөлөөллийг нийгэм хэрхэн даван туулж байгаагаар ангилж, зэрэглэх нь зүйтэй гэж үзжээ.

Дүгнэлт: Дээр авч үзсэн бүх судалгаанаас дүгнэвэл гамшиг нь ямар нэгэн аюулт үзэгдэл, осол тохиолдсон байх, түүний учруулсан хор уршгийг арилгахад өртсөн нийгмийн чадавх хүрэхгүй байх гэсэн хоёр үндсэн хүчин зүйлээр тодорхойлогдох үзэгдэл байна. Харин гамшгийн шалгуур үзүүлэлт нь аюулт үзэгдэл, осол тохиолдсон, түүний улмаас нийгэмд учирсан хор уршиг болон энэхүү хор уршгийг арилгах нийгмийн чадавхаар илэрхийлэгдэх ойлголт бол гамшгийн зэрэглэл нь тухайн гамшгийн үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүнд хариу арга хэмжээ авах удирдлага, зохицуулалтын хүрээг давхар харгалзсан ойлголт байна.

Монгол орны нөхцөлд тохирсон гамшгийн шалгуур үзүүлэлт, зэрэглэл тогтоох үндэслэл асуудлыг авч үзсэн судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

-Гамшгийн ангилал, зэрэглэл, шалгуур үзүүлэлтийг тогтоосон эрх зүйн орчин тодорхойгүй байдлаас шалтгаалан аюул, ослын цар хүрээ нь учруулсан хор уршиг болон хор уршгийг арилгахад зарцуулах эдийн засгийн чадавхаас давсан, хэтэрсэн нөхцөлөөр тодорхойлогдож байна.

-Гамшгийн шалгуур үзүүлэлт нь аюулт үзэгдэл, осол тохиолдсон, түүний улмаас нийгэмд учирсан хор уршиг болон энэхүү хор уршгийг арилгах нийгмийн чадавхаар илэрхийлэгдэх ойлголт бол гамшгийн зэрэглэл нь тухайн гамшгийн үзүүлэх сөрөг нөлөөлөл болон түүнд хариу арга хэмжээ авах удирдлага, зохицуулалтын хүрээг давхар харгалзсан ойлголт байна.

-Гамшгийг ангилал, төрлөөс хамааран тухайн нутаг дэвсгэрт гарсан аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, эрчимжилт, үргэлжлэх хугацаа, хүн ам, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, хамарслан цар хүрээ, учирсан хохирлын хэмжээг илэрхийлэх шалгуурыг зөв тодорхойлох нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хариуцлагатай, шуурхай, ил тод, хүмүүнлэг, мэргэжлийн нэгдмэл удирдлагатай, өмчийн хэлбэрийг үл харгалзан зохион байгуулах зарчмыг хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

¹ Henry W. Fischer, (2003) Гамшгийн социологи: Тодорхойлолт, судалгааны асуултууд, Хэмжилтүүд 9-р сарын 11-ний дараах байдлыг хэлэлцэх ажиллагааг үргэлжлүүлэх, Олон улсын гамшигт нэрвэгсэд, гамшгийн тухай олон улсын сэтгүүл, х. 91-107